

Худалдаа, хөгжлийн банкны
Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн
13 тоот тогтоолын Хавсралт 1




ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

Улаанбаатар хот
Монгол Улс
2023

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-ийн ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ



- 1.1. Худалдаа, хөгжлийн банк ХК (цаашид “Банк” гэх)-ийн энэхүү Дүрэм (цаашид “Дүрэм” гэх)-ээр Банкны эрх зүйн байдал, үйл ажиллагаа, Банк ба түүний удирдлагын тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц болон хувьцаа эзэмшигчийн эрх, үүрэг, хариуцлага, үйл ажиллагаанд хяналтыг тогтоох, эрх бүхий албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлага, Банкныг өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Банк нь Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, бие даасан тайлан тэнцэлтэй, Банкны харилцах данстай, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй, тусгайлсан эд хөрөнгөтэй, өөрийн үйл ажиллагаагаар эрх эдэлж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа үүсэн гарах үүргийг эд хөрөнгөөрөө хариуцдаг, шүүх, арбитрын өмнө өөрийн нэрийн өмнөөс оролцдог хуулийн этгээд байна.
- 1.3. Банк нь Монгол Улсын Банкны тухай хууль, Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа удирдлага болгон, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо (“СЗХ”)-ны тусгай зөвшөөрөлтэйгөөр, Дүрмийн хүрээнд ашгийн төлөө банкны нийтлэг үйл ажиллагаа явуулдаг, хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь Монгол Улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, нийтэд чөлөөтэй арилжаалагддаг нээлттэй хувьцаат компани байна.

ХОЁР. БАНКНЫ ОНООСОН НЭР, ХАЯГ, ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

- 2.1. Банкны оноосон нэрийг Монгол хэлээр “Худалдаа, хөгжлийн банк” ХК (товчоор “ХХБ”), Англи хэлээр “Trade and Development Bank” JSC (товчоор “TDB”) гэнэ.
- 2.2. Банкны хаяг:
Худалдаа, хөгжлийн банк,
14210 Энхтайваны өргөн чөлөө 19,
Сүхбаатар дүүргийн 1-р хороо,
Улаанбаатар, Монгол Улс
Утас: (976) 19001977, 18001977, 75111977, 70161977,
Факс: +976 70161988
Цахим шуудангийн хаяг: info@tdbm.mn
Цахим хуудас: www.tdbm.mn
- 2.3. Банк нь өөрийн тэмдэгтэй байх ба Банкны тэмдэг нь Банкны албан ёсны нэрийг Монгол болон Англи хэл дээр бүтнээр нь тусгасан байна. Банк нь барааны тэмдэгтэй байх бөгөөд түүний загварыг эрх бүхий байгууллагад бүртгүүлэн, зөвшөөрснөөр барааны болон үйлчилгээний тэмдэг, бэлгэдлийг дүрсэлж хэрэглэнэ.
- 2.4. Банк нь өөрийн барааны тэмдэг, бэлгэдэл болон хууль ёсны хаяг бүхий албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.
- 2.5. Банкны тухайн жилийн төсөв, төлөвлөгөөтэй уялдуулан байгуулах нэгжийн тоог Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ” гэх)-өөс тогтоох бөгөөд Монголбанкнаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагааг эхлүүлнэ. Банкны нэгж гэдгийг доор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 2.5.1. “Банкны салбар” гэж Монголбанкнаас Банканд зөвшөөрсөн бүх төрлийн үйл ажиллагааг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн эрхэлдэг нэгжийг хэлнэ. Салбар нь өөрийн харьяалалд тооцооны төв, тооцооны кастай байж болно;

- 2.5.2. **“Банкны тооцооны төв”** гэж иргэд, хуулийн этгээдийн харилцах, хадгаламж байршуулах, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхэлж, банкны төв болон банкны салбараас тогтоосон зээлийн эрх хэмжээний хязгаарлалтын хүрээнд зээлийн үйл ажиллагаа эрхлэх банкны төв, салбарын харьяалалд байх нэгжийг хэлнэ;
- 2.5.3. **“Банкны тооцооны касс”** гэж иргэд, хуулийн этгээдийн харилцах, хадгаламж байршуулах, гадаад төлбөр тооцооны энгийн зөвшөөрлийн хүрээнд гадаад валют худалдах, худалдан авах болон төлбөр тооцооны үйлчилгээ эрхлэх Банкны салбарын харьяалалд байх нэгжийг хэлнэ;
- 2.5.4. **“Банкны төлөөлөгчийн газар”** гэж Банкны оршин байгаа газраас өөр газар байрладаг бөгөөд банкны аливаа үйл ажиллагаа явуулдаггүй, зөвхөн Банкны хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, Банкны нэрийн өмнөөс хэлцэл хийх зэрэг эрх зүйн төлөөллийн үйл ажиллагаа явуулах нэгжийг хэлнэ.
- 2.6. Банкны нэгж нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй.
- 2.7. Банк нь хилийн чанад дахь үйл ажиллагаагаа Монгол Улсын олон улсын гэрээ, Иргэний эрх зүйд нийцүүлэн банкны үйл ажиллагаанд мөрдөгддөг олон улсын бизнесийн харилцааны түгээмэл зарчмуудыг баримтлан явуулна.

ГУРАВ. БАНКНЫ ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 3.1. **Банкны үйл ажиллагааны чиглэл.** “Худалдаа, хөгжлийн банк” ХК нь Монголбанкны зөвшөөрөлтэйгөөр банкны үйл ажиллагааг эрхэлнэ.
- 3.2. Банк нь Монголбанкны зөвшөөрөл авсны үндсэн дээр дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:
- 3.2.1. хадгаламж;
 - 3.2.2. зээл;
 - 3.2.3. төлбөр тооцооны үйлчилгээ;
 - 3.2.4. өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах;
 - 3.2.5. гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах;
 - 3.2.6. үнэт металл, эрдэнийн чулуу худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах;
 - 3.2.7. үнэт зүйл хадгалах;
 - 3.2.8. гадаад төлбөр тооцоо хийх;
 - 3.2.9. үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах;
 - 3.2.10. санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа;
 - 3.2.11. Зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах;
 - 3.2.12. Үндэсний төлбөрийн системийн тухай хуулиар зөвшөөрсөн үйл ажиллагаа.
- 3.3. Банк нь СЗХ-ноос зөвшөөрөл авсны үндсэн дээр дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:
- 3.3.1. санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх;
 - 3.3.2. итгэлцлийн үйлчилгээ;
 - 3.3.3. даатгалын зуучлагч;
 - 3.3.4. андеррайтерын үйлчилгээ;
 - 3.3.5. кастодианы үйл ажиллагаа;
 - 3.3.6. үнэт цаасны тухайлсан бүртгэлийн үйл ажиллагаа;
 - 3.3.7. факторингийн үйлчилгээ.
- 3.4. Банк нь холбогдох хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол үйл ажиллагаагаа хугацаагүйгээр явуулна.

ДӨРӨВ. БАНКНЫ ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

- 4.1. Банк нь нэг бүр нь 6,736.10 (зургаан мянга долоон зуун гучин зургаан төгрөг, арван мөнгө) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 55,000,000 (тавин таван сая) ширхэг зарласан энгийн хувьцаатай байна. Банк нь нийт 50,600,927 (тавин сая зургаан зуун мянга есөн зуун хорин долоо) ширхэг энгийн хувьцаа гаргасан болно. Давуу эрхийн хувьцаа гаргаж болно.



- 4.2. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаа эзэмшигчдээс оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний нийт хэмжээ нь Банкны зарласан хувьцааны хэмжээнд багтаан гаргасан энгийн хувьцааны үнийн дүн буюу 340,852,904,364.70 (гурван зуун дөчин тэрбум найман зуун тавин хоёр сая есөн зуун дөрвөн мянга гурван зуун жаран дөрвөн төгрөг, далан мөнгө) төгрөг байна.
- 4.3. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орох тохиолдолд холбогдох хууль, журмын дагуу эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх, зөвшөөрөл авснаар холбогдох өөрчлөлтийг оруулна.
- 4.4. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд дараах байдлаар өөрчлөлт орох тухай бүр Монголбанк, СЗХ-ноос урьдчилан зөвшөөрөл авна. Үүнд:
- 4.4.1. Банк хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах;
 - 4.4.2. Банкийг нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулах;
 - 4.4.3. Банкны нэгж хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх, эсхүл бууруулах;
 - 4.4.4. Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох;
 - 4.4.5. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Банкны нийт гаргасан хувьцааны 1 (нэг) болон түүнээс дээш хувиар хувьцаа нэмж эзэмших;
 - 4.4.6. Банк хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаасаа эргүүлэн худалдан авах.
- 4.5. Дүрмийн 4.4 дэх хэсэгт зааснаас бусад байдлаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт ороход холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Монголбанк, СЗХ, Монголын Хөрөнгийн Биржид мэдэгдэж, бүртгүүлнэ.

ТАВ. БАНКНЫ ХУВЬЦАА, ХУВЬЦААНД ХАМААРАХ БОЛОН БУСАД ҮНЭТ ЦААС

- 5.1. Холбогдох хууль тогтоомж, Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол хувьцаа эзэмшигч нь эзэмшиж буй хувьцааг чөлөөтэй захиран зарцуулах эрхтэй.
- 5.2. Банк нь Компанийн тухай хуульд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаасыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн ТУЗ-ийн шийдвэрээр гаргаж болно.
- 5.3. Банкны энгийн болон давуу хувьцаа эзэмшигч нь хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг барьцаалах, Монголбанкны зөвшөөрөлгүйгээр Банканд буцаан худалдахыг хориглоно.
- 5.4. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 66.66% хувь буюу дийлэнх олонхийн саналаар хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэж болно.
- 5.5. Банк нь хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг холбогдох хууль тогтоомж, Монголбанк, СЗХ, болон Монголын Хөрөнгийн Биржийн журамд нийцүүлэн үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 6.1. Банкны хувьцааг зохих журмын дагуу худалдан авч эзэмшсэн этгээд нь Банкны хувьцаа эзэмшигч байх бөгөөд өөрийн нэр, оршин суугаа хаяг болон өөрийн эзэмшилдээ байгаа үнэт цаасны тоо, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар бүртгэл хөтлөх этгээдэд холбогдох журмын дагуу мэдэгдэх үүрэгтэй байна.
- 6.2. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь Банкны тухай хуульд заасан шаардлагыг хангасан этгээд байх ба Банкны хувьцаа эзэмшигч байх хугацаандаа Банкны тухай хууль болон

холбогдох бусад хууль тогтоомж, журамд заасан Банкны хувьцаа эзэмшигчид тавигдах шаардлагыг ямагт хангах үүрэгтэй.

- 6.3. Банкны хувьцаа эзэмшигч нь өөрийн олж мэдсэн Банк, түүний нууцад хамаарах мэдээллийг бусад задруулах, Банкны нэрийг хувийн ашиг сонирхолд ашиглах, Банкны ажил хэргийн нэр хүнд, өмч хөрөнгөд гэм хор учруулж болзошгүй үйлдэл хийхийг хориглоно.
- 6.4. Банкны хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан худалдахаас бусад хэлбэрээр холбогдох хууль тогтоомжид зөвшөөрсний дагуу шилжүүлсэн бол хувьцаа эзэмшигчийн бүртгэл хөтлөх этгээд буюу үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй байна.
- 6.5. ТУЗ-өөс тогтоосон “бүртгэлийн өдөр” Банкны энгийн хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч нь хурлаар хэлэлцэж байгаа өөрийн саналын эрхтэй бүх асуудлаар санал өгөх эрхтэй бөгөөд нэг хувьцаа нь саналын нэг эрхтэй байна.
- 6.6. Банкны энгийн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар олгосон эрхийг эдлэх бөгөөд үүнд дараах эрх хамаарах боловч зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:
 - 6.6.1. ТУЗ-өөс тогтоосон “бүртгэлийн өдөр” Банкны хувьцааг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч хуралд оролцож (эсхүл өөрийн төлөөлөгчөөр дамжуулан оролцох), хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;
 - 6.6.2. Банкнаас зохих журмын дагуу хуваарилсан ногдол ашгийг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хууль тогтоомж, журамд заасан хугацаанд олгоогүй тохиолдолд алданги төлөхийг шаардах;
 - 6.6.3. Банкийг татан буулгаж эд хөрөнгийг нь хуваарилах тохиолдолд түүний үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааныхаа тоотой хувь тэнцүүлэн авах;
 - 6.6.4. Жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, Банкны нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр, тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо болон хууль тогтоомжид заасан бусад мэдээлэлтэй хүсэлтийн үндсэн дээр танилцах;
 - 6.6.5. Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй тохиолдолд Монголбанкны зөвшөөрөлтэйгөөр өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг Банкнаас шаардах эрхтэй.
 - 6.6.6. Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан хязгаарлалтыг хөндөхгүйгээр Банкнаас нэмж гаргах энгийн болон давуу эрхийн хувьцаа, түүнийг худалдан авах эрхийн бичиг болон тэдгээрт хөрвөх үнэт цаасыг өөрийн эзэмшиж буй энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тодорхой нөхцөлөөр тэргүүн ээлжинд худалдан авах, энэ эрхээ бусад этгээдэд бүхэлд нь буюу хэсэгчлэн шилжүүлж болно.
 - 6.6.7. Банкны эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуулийн 85 дугаар зүйлийн 85.2 дахь хэсэгт заасны дагуу хууль бус үйлдэл, эс үйлдлийн улмаас Банк, Хувьцаа эзэмшигч болон зээлдүүлэгчид хохирол учруулсан бол уг хохирлыг өөрийн хөрөнгөөр төлөхийг шаардах;
 - 6.6.8. Хууль тогтоомж болон Дүрмээр тогтоосон бусад эрх.
- 6.7. Банкны үйл ажиллагааны үндсэн мэдээллээс хэтийдсэн буюу худалдааны маш нууц, харилцагч, үйлчлүүлэгчийн нууц болон бусад бизнесийн мэдээлэл агуулсан баримт бичгийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулах үүргийг Банк хүлээхгүй.
- 6.8. Банк нь хувьцаа, опцион, хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах үйл ажиллагааг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, тогтоомж болон Монголбанк, СЗХ, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага болон бусад эрх бүхий зохицуулах байгууллагын холбогдох журамд нийцүүлэн хэрэгжүүлнэ.

- 6.9. Банкны хувьцаа эзэмшигч болохын хувьд хувьцаа эзэмшигч нь Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, Монголбанк, СЗХ, Монголын Хөрөнгийн Бирж болон бусад эрх бүхий байгууллага, албан тушаалтны тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлнэ.
- 6.10. Хувьцаа эзэмшигч нь санал өгөх эрхээ үндэслэлтэйгээр, шударгаар хэрэгжүүлэх үүрэгтэй.
- 6.11. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч (өөрөөр хэлбэл, хувьцааны тав ба түүнээс дээш хувийг дангаар болон Банкны тухай хуульд тодорхойлсон холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа этгээд, тэдгээрийн эцсийн өмчлөгч хүн, эсхүл Банкны бодлого, шийдвэр болон удирдлагад нөлөөлөхүйц хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч хүн) нь хуулийн этгээд бол эцсийн өмчлөгч, нэгдмэл сонирхолтой болон холбогдох этгээдийн талаарх мэдээллийг үнэн зөвөөр Банкаар дамжуулан Монголбанканд гаргаж өгнө. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь Банкны тухай хууль, Монголбанкны холбогдох журмаар тогтоосон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн тодорхойлолтод өөрчлөлт орох тухай бүр Банканд мэдэгдэж, зөвшөөрөл авна.
- 6.12. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон түүний эцсийн өмчлөгч хувьцаагаа бусдад шилжүүлэхдээ холбогдох хууль тогтоомж, Монголбанк, СЗХ зэрэг зохицуулах байгууллагуудын журам болон Дүрмийн шаардлага, Банкны эрх бүхий этгээдийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.
- 6.13. Банк нь хувьцаа эзэмшигчдийн хүлээх үүргийг хариуцахгүй. Хувьцаа эзэмшигч нь Банкны хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

ДОЛОО. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

- 7.1. Банкны эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.
- 7.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:
- 7.2.1. Банкны дүрэм батлах, уг дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу Банкны дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
 - 7.2.2. Банкийг нийлүүлэх, нэгтгэх, хуваах тусгаарлах буюу өөрчлөх замаар өөрчлөн байгуулах;
 - 7.2.3. Банкны өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
 - 7.2.4. Банкны хэлбэрийг өөрчлөх;
 - 7.2.5. Банкийг татан буулгах, татан буулгах комиссыг томилох;
 - 7.2.6. Банкны хувьцааг хуваах буюу нэгтгэх;
 - 7.2.7. Банкны зарласан хувьцааны хэмжээг тогтоох, өөрчлөх;
 - 7.2.8. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээг өөрчлөх;
 - 7.2.9. Банкны жилийн үйл ажиллагааны болон аудитын байгууллагаар баталгаажуулсан Банкны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 7.2.10. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлж буй этгээд нь шалгуур хангасан тухай Монголбанкны мэдэгдлийг хүлээн авсны үндсэн дээр Банкны ТУЗ-ийн гишүүнийг сонгох. Шаардлагатай тохиолдолд бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, чөлөөлөх;
 - 7.2.11. ТУЗ-ийн жилийн зардлын төсвийг батлах;
 - 7.2.12. Банкны хувьцаа эзэмшигчид нь хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэхийг Компанийн тухай хууль болон Дүрэмд заасны дагуу шийдвэрлэх;
 - 7.2.13. ТУЗ-өөс Компанийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
 - 7.2.14. Банк холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг зөвшөөрөх;
 - 7.2.15. ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр санал болгосон бусад асуудал;

- 7.2.16. холбогдох хууль тогтоомж болон Дүрэмд заасан хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх бусад асуудал.
- 7.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг ТУЗ-ийн шийдвэрээр дараах хэлбэрээр зохион байгуулж болно. Үүнд:
- 7.3.1. Танхимаар буюу хувьцаа эзэмшигчдийг биечлэн оролцуулах замаар;
 - 7.3.2. Мэдээллийн технологийн шийдэл ашиглан зайнаас буюу цахим хэлбэрээр;
 - 7.3.3. Танхимаар болон зайнаас хосолсон байдлаар;
 - 7.3.4. Ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар.
- 7.4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг ТУЗ-ийн шийдвэрээр жилд нэгээс доошгүй удаа санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор хуралдуулна.
- 7.5. ТУЗ нь Компанийн тухай хууль, Банкны тухай хуульд заасан үндэслэлээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.
- 7.6. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлах, хуралдуулахтай холбогдсон зардлыг Банк хариуцна.
- 7.7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэрт дараах мэдээллийг заана. Үүнд:
- 7.7.1. хурал хуралдуулах газар, он, сар, өдөр, цаг;
 - 7.7.2. хурлаар хэлэлцэх асуудал;
 - 7.7.3. хурал хуралдахаас өмнө хувьцаа эзэмшигчдэд танилцуулах бичиг баримтын жагсаалт;
 - 7.7.4. санал авах хуудасны агуулга;
 - 7.7.5. хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;
 - 7.7.6. хурал хуралдуулах хэлбэр;
 - 7.7.7. саналын хуудсаар санал урьдчилан авах тохиолдолд санал авах саналын хуудсыг хүлээн авах газар, сүүлчийн хугацаа;
 - 7.7.8. хуралд даргалах этгээдийн албан тушаал, нэр зэрэг Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэгт заасан бусад зүйлсийг заана.
- 7.8. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр гарсан өдрөөс хойш хуанлийн 40-өөс доошгүй хоногийн дараа ээлжит болон ээлжит бус хурлыг хуралдуулна.
- 7.9. Төлөөлөн удирдах зөвлөлийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэр гарсан тохиолдолд санал, шаардлага хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор тухайн хурлыг хуралдуулна.
- 7.10. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах, зарыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хувьцаа эзэмшигчид болон холбогдох эрх бүхий байгууллагад хүргэх зэрэг асуудлыг Банкны “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-аар нарийвчлан зохицуулна.
- 7.11. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг ТУЗ-өөс гаргасан хурал хуралдуулах тухай шийдвэрт заасан бүртгэлийн өдрөөр тасалбар болгон Банкны үнэт цаас эзэмшигчийн бүртгэлийг хөтлөх эрх бүхий этгээд гаргана.
- 7.12. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга буюу тухайн хурлыг зарласан этгээдийн хурал хуралдуулах шийдвэрт заасан этгээд удирдана. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол болон хурлын тэмдэглэлийг хууль тогтоомжид заасан журмын дагуу хөтлөх ба хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга гарын үсэг зурна.

- 7.13. Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад орсон хувьцаа эзэмшигч нь хуралд оролцох бөгөөд бүртгэлийн өдөр нь хурал хуралдуулах тухай шийдвэр гарсан өдрөөс өмнө байж болохгүй.
- 7.14. Шаардлагатай тохиолдолд саналын эрхтэй энгийн хувьцааны 5 болон түүнээс хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалд ороогүй, хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг нэмж оруулах саналыг гаргах эрхтэй ба нэмэлт асуудлыг хэлэлцэх эсэхийг тухайн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Бусад тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хуралд хэлэлцүүлэхээр оруулаагүй асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэхгүй.
- 7.15. Банкны саналын эрх бүхий энгийн хувьцааны тав буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах нэмэлт санал болон ТУЗ, тооллогын комиссын дарга, гишүүнд нэр дэвшүүлэх хүний талаарх саналаа өмнөх санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор ТУЗ, эсхүл гүйцэтгэх удирдлагад гаргаж болно. Гүйцэтгэх удирдлага нь тус саналыг ТУЗ-д ажлын 3 өдөрт багтаан хүргүүлнэ.
- 7.16. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хурал зарласан мэдэгдлийг зохих журмын дагуу бэлтгэх, хүргүүлэх зэрэг хурлын бэлтгэлийг хангуулах ажлыг хариуцна.
- 7.17. Банкны саналын эрх бүхий хувьцааны 50 (тавь)-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно. Саналын хуудсаар саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсонд тооцно.
- 7.18. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулахыг хориглоно.
- 7.19. Банкны хувьцаа эзэмшигчид нь хувьцаа эзэмшигчдийн хурал, эсхүл эчнээ санал хураалтаар шийдвэр гаргах үед саналаа саналын хуудсаар тогтоосон журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисст хүргүүлнэ.
- 7.20. Дүрмийн 7.17 дахь хэсэгт заасан ирц бүрдээгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэж, дахин хуралдах өдрийг товлон. Хойшлогдсон хурал хуралдуулах асуудлыг дараах журмаар зохицуулна. Үүнд:
- 7.20.1. хойшлогдсон хурлыг ажлын 20 (хорь) хоногийн дотор хуралдуулах бөгөөд хурал болох газар, өдөр, цагийг хурал хуралдахаас 7 (долоо) ба түүнээс доошгүй хоногийн өмнө дахин мэдээлнэ. Харин хойшлогдсон хурлаар хэлэлцэхээр товлосон асуудлыг өөрчилж үл болно;
- 7.20.2. хурлаар хэлэлцэх асуудлыг өөрчлөөгүй нөхцөлд саналын эрхийн 20 (хорь) ба түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хойшлогдсон хурал хүчин төгөлдөр болно;
- 7.20.3. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 - 62.1.6 дахь заалтуудад заасан асуудлыг хэлэлцэх хойшлогдсон хурал нь саналын эрхийн гуравны нэгээс доошгүй хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор хүчин төгөлдөр болно;
- 7.20.4. түрүүчийн хуралд бичгээр ирүүлсэн саналыг хойшлогдсон хурлын ирц, тухайн хэлэлцэх асуудлын санал хураалтын дүнд оруулан тооцно;
- 7.20.5. хойшлогдсон хурал нь ажлын 20 (хорь) хоногийн дотор хуралдаж чадахгүй бол шинээр хурал зарлах бөгөөд ийнхүү шинээр зарласан хурлын ирц (кворум)-ийг энэ Дүрмийн 7.17 дахь хэсэгт зааснаар тооцно.
- 7.21. Хувьцаа эзэмшигч нь хурлаас гарах шийдвэрт өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан саналаа өгч болно. Итгэмжлэл нь бичгээр үйлдэгдэж, нотариатаар гэрчлэгдсэн, итгэмжлэгч, итгэмжлэгдэгчийн овог нэр, иргэний үнэмлэх, регистрийн дугаар, итгэмжлэлээр олгож байгаа эрх буюу Иргэний хуульд заасан шаардлагыг хангасан байна. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь хувьцаа эзэмшигчдийн хурлаас өмнө итгэмжлэлийг ТУЗ-д мэдэгдэж,

итгэмжлэлийг санал хураалт эхлэхээс өмнө хурлын нарийн бичгийн даргад өгсөн байх бөгөөд түүнийг тухайн хурлын холбогдох баримт бичгүүдийн хамт хадгална. Төлөөлөх итгэмжлэл нь зөвхөн тухайн хуралд хүчинтэй байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал хойшилсон боловч хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл дараагийн хуралд хүчинтэй байна.

- 7.22. Дүрмийн 7.2.1-7.2.6 дахь заалтуудад заасан асуудлыг хуралд оролцож буй саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн 66.66% хувь буюу дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. ТУЗ-ийн гишүүдийг Компанийн тухай хууль болон энэхүү Дүрэмд заасны дагуу кумулятив аргаар сонгож, түүнээс бусад асуудлыг хуралд оролцож буй саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

НАЙМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

- 8.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Банкны эрх барих байгууллага нь ТУЗ байна. ТУЗ нь нийт 9 (ес) гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 6 (зургаа) гишүүн нь ердийн, 3 (гурав) гишүүн нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас кумулятив аргаар сонгоно. ТУЗ-ийн үйл ажиллагаа явуулах хэлбэр нь ТУЗ-ийн хурал байна.
- 8.2. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа нь сонгогдсоноор эхэлж, түүнийг ТУЗ-ийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлснөөр дуусгавар болно.
- 8.3. ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулаагүй тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас бусад хууль болон Дүрмээр тодорхойлсон ТУЗ-ийн бүрэн эрх дуусгавар болно.
- 8.4. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос ТУЗ-ийн саналын эрхтэй нийт гишүүний олонхийн саналаар сонгоно. ТУЗ-ийн даргад нэр дэвшигч нь өөртөө санал өгөхгүй. ТУЗ-ийн даргыг түр эзгүйд түүний үүрэг гүйцэтгэгчийг ТУЗ-ийн дарга эсхүл ТУЗ-ийн хурлаас томилно.
- 8.5. Банкны ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүн нь Банкны тухай хууль, Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Дүрэмд заасан мэргэжил, боловсрол, ёс зүйн болон бусад шалгуурыг хангасан байх бөгөөд бүрэн эрхийнхээ хугацаанд тогтмол хангаж ажиллана.
- 8.6. ТУЗ-ийн гишүүн удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл бусад хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд түүнийг орлох этгээдийг дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар нөхөн сонгууль явуулах хүртэл ТУЗ түр томилж болно.
- 8.7. ТУЗ-ийн хараат бус гишүүдийг ТУЗ-ийн гишүүнд сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх, хараат бус гишүүн ажлаа тайлагнахтай холбоотой асуудалд Банкны тухай хууль болон Монголбанкнаас баталсан "Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам", СЗХ-ноос баталсан Компанийн засаглалын кодексийг удирдлага болгоно.
- 8.8. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь түүний хараат бус байдал нь алдагдах нөхцөл үүссэн тохиолдолд ТУЗ-д нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.
- 8.9. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Банкны Аудитын хороо, Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо болон Эрсдэлийн удирдлагын хороонд ажиллаж, түүний гишүүн байна. Эдгээр хорооны эрхэлсэн асуудал болон Компанийн тухай хуульд заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад оролцож, санал өгнө.
- 8.10. ТУЗ нь жилд 1 (нэг)-ээс доошгүй удаа хувьцаа эзэмшигчдийн хуралд ажлаа тайлагнана. ТУЗ-ийн дарга, гишүүн нь Банкны тухай хуульд заасны дагуу дараах үүрэгтэй байна. Үүнд:

- 8.10.1. Хууль тогтоомж болон Дүрмээр олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажил, үүргээ идэвхитэй, хариуцлагатай биелүүлэх;
 - 8.10.2. Банк, Банкны харилцагчийн эрх ашгийг хувийн болон өөрийг нь сонгосон этгээдийн эрх ашгаас дээгүүр тавих, Банкны ашиг сонирхлын төлөө, үнэнч шударгаар ажиллах;
 - 8.10.3. нууцаар ашиг хүртэхгүй байх;
 - 8.10.4. сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн үед ТУЗ-д мэдээлдэг байх;
 - 8.10.5. Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй байх;
 - 8.10.6. Ажил үүргээ гүйцэтгэх явцаа олж мэдсэн нууц болон нийтэд тараагдаагүй мэдээллийг өөрийн хувийн ашиг сонирхол буюу бусад этгээдийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байх;
 - 8.10.7. ТУЗ-ийн хуралд идэвхтэй оролцож, ажлын туршлага, өөрийн мэдлэг, ур чадвар, нөөц бололцоог дайчлах, хувьцаа эзэмшигчдийн хуралд ажлаа тайлагнах.
- 8.11. ТУЗ нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад асуудал буюу дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 8.11.1. Банкны стратегийг тодорхойлох, хянан үзэж түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, эрсдэлийн удирдлагын бодлого, жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлах;
 - 8.11.2. Банкны удирдлага, зохион байгуулалтын ерөнхий бүтцийг тогтоох;
 - 8.11.3. Монголбанкны зөвшөөрснөөр Банкны Гүйцэтгэх удирдлагыг томилох;
 - 8.11.4. Банкны Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх, хариуцлагыг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих, түүнийг ажлаас түдгэлзүүлэх, чөлөөлөх;
 - 8.11.5. Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, эрх, үүрэг, хариуцлагын хэмжээг тогтоох, түүнд олгох цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
 - 8.11.6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
 - 8.11.7. Банкны дотоод аудитын нэгжийг гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар зохион байгуулж, түүний төсөв, орон тоог батлах, удирдлага, ажилтныг томилох, үйл ажиллагааны дүрэм, журмыг тогтоох, цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
 - 8.11.8. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийг тодорхойлох бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
 - 8.11.9. Банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гарган хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж хэлэлцүүлэх;
 - 8.11.10. Банкны эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
 - 8.11.11. Хувьцааны үнийг тогтоох;
 - 8.11.12. Банкны зарласан хувьцааны төрөл болон хэмжээнд багтаан хувьцаа гаргах;
 - 8.11.13. Дүрэмд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах;
 - 8.11.14. Банк өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;
 - 8.11.15. Аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;
 - 8.11.16. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэр гаргах;
 - 8.11.17. Гадаад улсад Банкны нэгж байгуулах;
 - 8.11.18. Банкийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төсөл бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
 - 8.11.19. Компанийн тухай хуульд заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
 - 8.11.20. Компанийн тухай хуульд заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
 - 8.11.21. Банкны зохистой засаглалын бодлого, журмууд болон ёс зүйн дүрмийг тогтоож, хэрэгжилтэд хяналт тавих;
 - 8.11.22. Банкны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудит, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналт, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хамарсан зохистой хяналтын тогтолцоог бүрдүүлэх;
 - 8.11.23. Хууль тогтоомжид заасны дагуу нийтэд мэдээлэх санхүүгийн тайлан, бусад мэдээллийг мэдээлэх явцад хяналт тавих;
 - 8.11.24. ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүдийг сонгох, чөлөөлөх, хороодын ажиллах журмыг батлах;

- 8.11.25. Монголбанк, СЗХ, бусад эрх бүхий зохицуулах байгууллагаас тогтоосон болон банкны заавал биелүүлэх зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг Банк хэрхэн хангаж ажиллаж байгаад хяналт тавих;
- 8.11.26. Хууль тогтоомж болон Дүрмээр зөвшөөрсөн бусад асуудал.
- 8.12. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Дүрмийн 8.11.10, 8.11.15, 8.11.20-д заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд оролцож саналаа өгнө.
- 8.13. ТУЗ-ийн дарга нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
- 8.13.1. ТУЗ-ийн гишүүдийг чиг үүргээ гүйцэтгэх нөхцөл бололцоогоор хангах, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын хооронд харилцан хүндлэл, итгэлцэл дээр тулгуурласан ажил хэрэгч харилцааг үүсгэн бэхжүүлэх;
- 8.13.2. ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих;
- 8.13.3. Тухайн асуудлаар шийдвэр гаргахад ТУЗ-ийн дэргэдэх хороодын дүгнэлтийг үндэслэх;
- 8.13.4. ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаанд хяналт тавих;
- 8.13.5. ТУЗ-ийг төлөөлж Гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулах;
- 8.13.6. ТУЗ-ийн гишүүнийг зохистой засаглалын сургалтад хамруулах, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийг батлан гаргаж, хэрэгжүүлэх.
- 8.14. ТУЗ-ийн хурал хуралдуулахтай холбоотой асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.
- 8.15. ТУЗ-ийн ээлжит хурлыг улиралд 1 (нэг)-ээс доошгүй удаа хийж, шаардлагатай бол ээлжит бус хурал хийж болно.
- 8.16. ТУЗ-ийн ээлжит бус хурлыг ТУЗ-ийн дарга, гишүүд, Гүйцэтгэх удирдлага болон хууль тогтоомж, Дүрэмд заасан бусад этгээдийн санаачилга, шаардлагаар хуралдуулж болно.
- 8.17. ТУЗ-ийн гишүүн нь хуралд өөрийн биеэр оролцох ба өөрийн биеэр оролцох боломжгүй бол ТУЗ-ийн гишүүн нь эчнээ санал хураалтаар шийдвэр гаргах буюу өөрийн саналаа саналын хуудас бөглөх замаар өгч болно.
- 8.18. ТУЗ-ийн гишүүдийн 66.66% хувь буюу дийлэнх олонхи оролцсоноор ТУЗ-ийн хурал хүчин төгөлдөр болно.
- 8.19. Хууль эсхүл Дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийн хуралд оролцож буй гишүүдийн 66.66% хувь буюу дийлэнх олонхийн саналаар хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно.
- 8.20. ТУЗ-ийн шийдвэр нь тогтоол байна. Тогтоолд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж банкны тэмдэг дарна. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурна. Хэрэв тийнхүү зурахаас татгалзсан бол тухайн гишүүн тайлбараа бичгээр гаргана.
- 8.21. ТУЗ-ийн хуралд гишүүн телефон утас эсхүл техник технологи ашиглан оролцож болно. Гэхдээ хуралд оролцож буй бүх хүмүүс яриаг нь сонсох, түүнтэй ярих боломжтой байна. Ийм хэлбэрээр оролцсон ТУЗ-ийн гишүүнийг тухайн хурлын үндсэн ирцэд тооцож, тухайн асуудлыг хэлэлцэх хуралд биеэр оролцсонд тооцно. ТУЗ-ийн гишүүн-телефон утас эсхүл техник технологи ашиглан хуралд оролцсон тохиолдолд түүний яриа, саналыг дуу бичлэгийн хальсанд буулгаж хадгалах ба шаардлагатай бол хурлын тэмдэглэлийг өөрт нь танилцуулж гарын үсэг зуруулан баталгаажуулна.
- 8.22. ТУЗ-ийн гишүүн нь хурлаар хэлэлцэж, шийдвэрлэх асуудлын талаар саналаа бичгээр ирүүлэх замаар хуралд оролцож болно. ТУЗ-ийн гишүүнээс бичгээр ирүүлсэн саналыг хурал даргалагч хурлын үеэр танилцуулах ба саналын хуудсыг хурлын тэмдэглэлд хавсаргаж, зохих журмын дагуу хадгална. ТУЗ-ийн хурлаар хэлэлцэхээр зарласан үндсэн асуудлуудад саналын хуудсаар

саналаа илгээсэн ТУЗ-ийн гишүүнийг тухайн хурлын үндсэн ирцэд тооцож, тухайн асуудлыг хэлэлцэхэд биечлэн оролцсонд тооцно.

ЕС. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

- 9.1. ТУЗ нь дэргэд Аудитын хороо, Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо, Эрсдэлийн удирдлагын хороо гэсэн гурван (3) хороодтой байна. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Хороод нь өөрсдийн чиг үүргийн хүрээн дэх асуудлаар дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулах, Компанийн тухай хуульд заасан зарим асуудлаар шийдвэр гаргах эрх хэмжээтэй байна.
- 9.2. Аудитын хороо нь хорооны дарга, гишүүдээс бүрдсэн байх бөгөөд гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна. Аудитын хорооны дарга, гишүүд нь санхүүгийн тайлагналын зохих мэдлэг, туршлагатай байна. Аудитын хорооны дарга нь Банкны хөндлөнгийн аудитортой аливаа холбоогүй, сүүлийн 3 жилийн хугацаанд тухайн хөндлөнгийн аудитын компанид ажиллаж байгаагүй, ТУЗ-ийн дарга биш бөгөөд ТУЗ-ийн хараат бус гишүүн байх ба уг хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлж, дүгнэлт гарган ТУЗ-д танилцуулна. Үүнд:
- 9.2.1. Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
- 9.2.2. Дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;
- 9.2.3. Хувьцаа эзэмшигчдийн санал, гомдлын дагуу банкны санхүүгийн үйл ажиллагааг хянан шалгах;
- 9.2.4. Компанийн тухай хуульд заасан үндэслэл, журмаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахыг шаардах;
- 9.2.5. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;
- 9.2.6. Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах ба Аудитын хорооны дарга нь компанийн хөндлөнгийн аудитортой аливаа холбоогүй, сүүлийн гурван жилийн хугацаанд тухайн хөндлөнгийн аудитын компанид ажиллаж байгаагүй байна;
- 9.2.7. Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулах;
- 9.2.8. Дүрэм, холбогдох хууль, Компанийн засаглалын кодекс болон ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.
- 9.3. Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо нь хорооны дарга, гишүүдээс бүрдсэн байх бөгөөд гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна. Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлж, Компанийн тухай хуульд заасан асуудлаар дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулна. Үүнд:
- 9.3.1. Банкны эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын бодлогыг боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
- 9.3.2. Банкны жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсанд цалин урамшууллын бодлогын баримт бичиг, хорооны үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүний дэлгэрэнгүй мэдээлэл, хурлын давтамж, ирц, зэргийг нийтэд мэдээлэх;
- 9.3.3. Банкны ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зэрэг хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн шийдвэрээр томилогддог албан тушаалтны орон тоо гарсан, эсвэл тэдгээрийн залгамж халааг бэлтгэх шаардлагын үүднээс судалж, нэр дэвшүүлэх;
- 9.3.4. ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зэрэг хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн шийдвэрээр томилогддог албан тушаалтантай байгуулах гэрээ Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, цалин урамшууллын асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ийн хурлаас баталсан төсөвт багтаан шийдвэрлэх;

- 9.3.5. Банкны цалин, урамшууллын бодлого, шалгуур, хэмжээ нь Банкны хөгжлийн стратеги, зах зээлд эзлэх байр суурь, хөдөлмөрийн зах зээлийн байдалд хэрхэн нийцэж байгаад тогтмол хяналт тавьж ажиллах;
- 9.3.6. Хууль тогтоомжоор тавигдсан шалгуурыг ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх удирдлага хангаж байгаа эсэхэд хяналт тавьж, ТУЗ-д танилцуулах;
- 9.3.7. Банкны залгамж халааны бодлогыг боловсруулж ТУЗ-өөр батлуулах;
- 9.3.8. Банкны жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсанд залгамж халааны бодлогын баримт бичиг, хорооны үйл ажиллагааны журам, хурлын давтамж, ирц зэргийг нийтэд мэдээлэх;
- 9.3.9. Банкны эрх бүхий албан тушаалтны мэдлэг, ур чадвар, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох, тухайн ажлын байрны шаардлагыг хангаж байгаа эсэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн бие даасан хараат бус байдал зэргийг тогтоох ба уг хороо нь тэдгээрийг сургах, мэргэшүүлэх ажлыг хариуцах, үнэлэлт, дүгнэлт өгөх;
- 9.3.10. Банкны ажилтнуудын жендерийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх;
- 9.3.11. Дүрэм, холбогдох хууль, Компанийн засаглалын кодекс болон ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.
- 9.4. Эрсдэлийн удирдлагын хороо нь хорооны дарга, гишүүдээс бүрдсэн байх ба Эрсдэлийн удирдлагын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 9.4.1. Банкны эрсдэлийн удирдлагын бодлого, эрсдэлийн чиг хандлага, эрсдэл даах чадамжийг тодорхойлон ажиллах, эрсдэлийн удирдлагын олон улсын тогтолцоо, үндсэн шаардлагууд, практик аргачлалыг Банканд нэвтрүүлэх талаар зөвлөмж гаргах;
- 9.4.2. Банкны эрсдэлийн удирдлагын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлж, тэдгээрийн эрсдэлийг тогтоох, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг хянах, бууруулах, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөх, эрсдэлийн удирдлагыг сайжруулах шат дараалсан хөтөлбөр гаргах;
- 9.4.3. Банкны бизнесийн зорилтот байдалд нийцүүлэн эрсдэлийн удирдлагын хэм хэмжээ, эрсдэл даах чадамжийг үнэлэн дүгнэж, шаардлагатай өөрчлөлт оруулахыг холбогдох Банкны хороодод үүрэг өгөх, зөвлөмж гаргах;
- 9.4.4. Дүрэм, холбогдох хууль, Компанийн засаглалын кодекс болон ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.
- 9.5. Аудитын хороо, Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо, болон Эрсдэлийн удирдлагын хороодын үйл ажиллагааг ТУЗ-өөс баталсан тус бүрийн журмаар зохицуулна.
- 9.6. Аудитын хороо, Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо болон Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүдийг сонгох болон чөлөөлөх тухай асуудал мөн хороодын бүрэн эрх, үүрэг хариуцлагыг хороодын дүрэм, журамд тусгах ба тухайн дүрэм, журам нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Монголбанкны дүрэм, журам болон СЗХ-ны холбогдох бусад журамд нийцсэн байна.

**АРАВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА**

- 10.1. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ-ийн хурлаас томилно. ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эзгүйд түүнийг орлох этгээдийг томилно.
- 10.2. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Компанийн тухай хуульд заасан ТУЗ-ийн үүргээс гадна Банкны нийт хувьцаа эзэмшигчид, ТУЗ-тэй холбоотой асуудлыг эрхлэн гүйцэтгэх, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын ажлын харилцан уялдаа холбоог хангах, хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлыг хуралдуулах ажлыг зохион байгуулах, хурлын тэмдэглэл хөтлөх, хурлын шийдвэрийн биелэлтийг хангуулах, ТУЗ-ийн бичиг хэргийг хариуцан хөтлөх болон хууль, тогтоомж, хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-өөс түүнд хариуцуулсан ажлуудыг Компанийн



тухай хууль, энэхүү Дүрэм болон Банкны ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасныг удирдлага болгон, хариуцан гүйцэтгэнэ.

- 10.3. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Банкны ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу холбогдох этгээдээс мэдээллийг хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах, архивд шилжүүлэх зэрэг ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

АРВАН НЭГ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

- 11.1. Банкны гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-өөс томилогдсон Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.
- 11.2. Гүйцэтгэх захирал нь Банкны тухай хууль, Компанийн тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжийн шаардлагыг хангасан Монголбанкнаас зөвшөөрсөн хувь хүн байна.
- 11.3. Гүйцэтгэх захирал нь Банкны өдөр тутмын үйл ажиллагааг хууль тогтоомж, Банкны дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам заасан эрх хэмжээний хүрээнд удирдан зохион байгуулж, ТУЗ-д ажлаа тайлагнана.
- 11.4. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болно. Харин ТУЗ-ийн дарга байхыг хориглоно.
- 11.5. Гүйцэтгэх захирлын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин хөлс, урамшуулал, нөхөн олговор, ногдох хариуцлага зэрэг асуудлыг ТУЗ-өөс тогтоон, гэрээнд тусгана.
- 11.6. Гүйцэтгэх захирлын эдлэх эрх хэмжээг түүнтэй байгуулсан гэрээ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журамд тодорхой тусгах бөгөөд Гүйцэтгэх захирал нь доор дурдсан үүрэг хүлээж, эрх эдэлнэ. Үүнд:
- 11.6.1. Банкны стратеги, жил бүрийн бизнесийн төлөвлөгөө, төсвийг ТУЗ-д танилцуулж, ТУЗ-өөс баталсан төлөвлөгөө, төсөв, шийдвэрийг хэрэгжүүлэх;
 - 11.6.2. холбогдох хууль тогтоомжийн дагуу өөрийн хамаарах асуудлаар Банкны дотоодод мөрдөгдөх бодлого, заавар, журам болон аливаа эрх зүйн баримт бичгийг тушаал гарган батлах, мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;
 - 11.6.3. Банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, тушаал гаргах, биелэлтийг хангуулах;
 - 11.6.4. Дүрэм болон холбогдох хууль тогтоомж, Банкны хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, тухайн жилийн бизнес төлөвлөгөө, Монголбанкнаас Банкны тухай хууль, СЗХ-ноос Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжийн заалтад нийцүүлэн өгсөн үүрэг даалгавар болон ТУЗ-ийн шийдвэр, үүрэг, даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;
 - 11.6.5. Хувьцаа эзэмшигчид, харилцагчийн өмнө хүлээсэн үүргийг биелүүлэх, өөрийн Банкны санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;
 - 11.6.6. Банк, түүний хадгаламж эзэмшигчид, харилцагчийн эрх ашгийг хувийн эрх ашгаасаа илүүд тавьж, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан банк, түүний салбар, тооцооны төв, кассуудын үйл ажиллагааг зохицуулан удирдах, тэдгээрийг удирдлагыг томилох, чөлөөлөх;
 - 11.6.7. үүрэг гүйцэтгэх явцад олж авсан Банк, түүний харилцагчийн талаарх мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх, нууцыг чандлан хадгалах;
 - 11.6.8. Банкны ажилтан албан үүргээ ашиг, сонирхлын зөрчилгүйгээр гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх;
 - 11.6.9. Банкны хэвийн ажиллагааг хангахуйц дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх, түүнд үнэлэлт, дүгнэлт өгч байх;
 - 11.6.10. ТУЗ-өөс баталсан зардлын хэмжээнд багтаан банкны ажилтнуудын орон тоо, үндсэн болон нэмэгдэл цалин, тэтгэмж, хөнгөлөлт, урамшууллын хэмжээг тогтоох;
 - 11.6.11. ажилтнуудын ажил үүргийн хуваарийг тогтоох, ажилтныг ажилд томилох, шилжүүлэх, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх;

- 11.6.12.олгогдсон эрх хэмжээний хүрээнд Банкны нэрийн өмнөөс баталгаа, батлан даалт гаргах, гэрээ хэлцэл байгуулах;
- 11.6.13.Банкны үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;
- 11.6.14.мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах;
- 11.6.15.Банкны нэгж байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Дүрмийн 2.5 дахь хэсгийг үндэслэн шийдвэрлэх;
- 11.6.16.Дүрэмд болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан үүргээ биечлэн гүйцэтгэх;
- 11.6.17.санхүүжилт, зээлжүүлэлттэй холбогдсон хөрөнгийн баталгаа гаргах, тэдгээртэй байгуулсан гэрээний үндсэн дээр холбогдох мэдээ, тайланг харилцагчаас шаардан авах, тэдний тайлан тэнцэлтэй танилцах, шалгах, хууль тогтоомжийн дагуу хөрөнгийг барьцаанд авах, дансны гүйлгээг түр хаах;
- 11.6.18.Банкны хууль ёсны эрх ашгийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхээр шүүхэд нэхэмжлэл гаргах, Банканд холбогдох иргэн, захиргааны хэрэгт нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцох, эрүүгийн хэрэгт хохирогч, иргэний нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон оролцуулах;
- 11.6.19.хувийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлыг хэлэлцэхэд оролцохгүй байх;
- 11.6.20.Банкны нэгжийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээ, нэг этгээдэд олгох зээлийн дээд хэмжээг тогтоох, зээлийн үлдэгдэлд хязгаарлалт хийж, хяналт тавих;
- 11.6.21.шаардлагатай гэж үзвэл хадгаламж эзэмшигч, харилцагчдын болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор тухайн салбар, нэгжийн үйл ажиллагааг зохицуулахтай холбогдсон тусгай дүрэм, журам гаргах, салбар, нэгжийн үйл ажиллагаанд тодорхой хязгаарлалт тогтоох зэрэг шийдвэртэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- 11.6.22.Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам, Банкны дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан үүргээ биечлэн гүйцэтгэх;
- 11.6.23.Банктай хийх хэлцлийн нөгөө тал, эсхүл зуучлагч, төлөөлөгчөөр оролцож байгаа этгээд нь Гүйцэтгэх захиралтай нэгдмэл сонирхолтой, хамаарал бүхий этгээд байх тохиолдолд энэ тухай ТУЗ-д мэдэгдэж, Банкны их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам болон холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгох;
- 11.6.24.Банкны Ёс зүйн дүрмийг ажлын болон ажлын бус цагт мөрдөх;
- 11.6.25.Банкнаас хөрөнгө захиран зарцуулах төлбөрийн баримтад гарын үсэг зурах;
- 11.6.26.онц байдал, гамшиг, аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын үед банкны хэмжээнд авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, тусгай дүрэм журам батлах, нэн яаралтай үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тушаал гаргах, хяналт тавих;
- 11.6.27.Гадаад эсхүл дотоодын банк, санхүүгийн зах зээлээс санхүүжилт татах зорилгоор хувьцаагаар солигдох нөхцөлтэй хоёрдогч өглөгөөс бусад дараах хэлцлийг ТУЗ-өөс олгосон зөвшөөрлийн хэмжээнд хийх эрхтэй. Үүнд:
- 11.6.27.а. Үнэт цаас гаргах;
- 11.6.27.б. Зээл, түүнтэй адилтгах санхүүгийн үйлчилгээ авах;
- 11.6.27.в. Баталгаа, батлан даалт гаргуулах;
- 11.6.27.г. Зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах.
- 11.6.28.Монголбанк, СЗХ болон бусад эрх бүхий зохицуулах байгууллагаас тогтоосон болон Банкны заавал биелүүлэх зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангуулж ажиллах;
- 11.6.29.ТУЗ-өөс урьдчилж олгосон зөвшөөрөл, тодорхойлсон нөхцөлийн хүрээнд сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл байгуулах;
- 11.6.30.Хууль тогтоомж, гэрээнд заасан болон ТУЗ-өөс эрх олгосон бусад эрх, үүрэг.
- 11.7. Гүйцэтгэх захирал ээлжийн амралт эдлэх, гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар ажил, үүргээ биечлэн гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд өөрийн эрх, үүргийг хэсэгчлэн болон бүхэлд нь Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч эсхүл Гүйцэтгэх захирлын орлогчид итгэмжлэлээр шилжүүлнэ.
- 11.8. Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл, зээл, хадгаламжийн хүү, үйлчилгээний шимтгэл, хураамжийн хэмжээг Гүйцэтгэх захирлын тушаалаар тогтооно.

- 12.1. Банкны албан ёсны шийдвэрийг гаргах, гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог доорх этгээдийг Банкны эрх бүхий албан тушаалтанд тооцно. Гүйцэтгэх захирлын тушаалаар ажил үүрэг, үйл ажиллагааны чиглэлээр хариуцан гүйцэтгэж буй эрх бүхий албан тушаалтныг нарийвчлан тогтоож болно. Үүнд:
- 12.1.1. ТУЗ-ийн дарга, гишүүд;
 - 12.1.2. Гүйцэтгэх захирал;
 - 12.1.3. Ерөнхийлөгч;
 - 12.1.4. Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч;
 - 12.1.5. Дотоод аудитын газрын захирал;
 - 12.1.6. Санхүүгийн удирдлага, хяналтын газрын захирал;
 - 12.1.7. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга.
- 12.2. Эрх бүхий албан тушаалтан нь хууль, тогтоомж, Банкны Дүрэм, ТУЗ-өөс баталсан журмуудад заасан үүргийг биелүүлж, Банкны ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана.
- 12.3. Эрх бүхий албан тушаалтан дараах хууль бус үйлдэл хийсний улмаас Банканд учирч болох хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцна. Үүнд:
- 12.3.1. хувийн ашиг сонирхлын үүднээс Банкны нэрийг ашиглан аж ахуйн үйл ажиллагаа явуулсан;
 - 12.3.2. Хувьцаа эзэмшигчид, зээлдүүлэгч болон бусад харилцагчдад хуурамч мэдээлэл өгсөн;
 - 12.3.3. мэдээлэл өгөх үүргээ биелүүлээгүй;
 - 12.3.4. Банкны бичиг баримтыг хууль, тогтоомжид заасан журмын дагуу хадгалаагүй;
 - 12.3.5. Компанийн тухай хуулийн 98 дугаар зүйлд заасан мэдээллийг мэдээлэл авах эрх бүхий этгээдэд гаргаж өгөөгүй, хугацаа хожимдуулан гаргаж өгсөн;
 - 12.3.6. Банкны дүрэм, Банкнаас баталсан дотоод журмыг биелүүлээгүй, Банкны нууц мэдээг гурав дахь этгээдэд хууль, тогтоомж, Банкны дүрэм, журам, зааврыг зөрчиж дамжуулсан, эсхүл хувийн зорилгод ашигласан;
 - 12.3.7. Банкны Дүрэм, Банктай байгуулсан гэрээ, Банкны шийдвэрээр тогтоосон эд хөрөнгө захиран зарцуулах эрх хэмжээг хэтрүүлсэн;
 - 12.3.8. Банкны үйл ажиллагаанд мөрдөгддөг хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн.
- 12.4. Эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, түүний хэмжээг тогтоох асуудлыг Банктай байгуулсан гэрээ, Банкны дотоод журмаар тогтоох бөгөөд хэрэв тэдгээрийн дагуу шийдвэрлэх боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 12.5. Банкны эрх бүхий албан тушаалтан нь тухайн албан тушаалд томилогдсоноос хойш 10 (арав) хоногийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж, Банканд өгөх бөгөөд мөн уг жагсаалтад өөрчлөлт орсон тухай бүрд нь 10 (арав) хоногийн дотор мэдэгдэнэ.

АРВАН ГУРАВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАЛТ

- 13.1. Ногдол ашиг хуваарилан олгох эсэх асуудлыг ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдахаас өмнө хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Ногдол ашиг хуваарилан олгох ажлыг ТУЗ-өөс тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ. Ногдол ашиг хуваарилахаас өмнө ашгаас нөөцийн сан байгуулж болно.
- 13.2. ТУЗ-ийн тогтоолд хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах “бүртгэлийн өдөр” болон ногдол ашиг төлж эхлэх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэнэ.
- 13.3. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ашиг хуваарилна. Ногдол ашгийг бэлэн мөнгө, эд хөрөнгө, түүнчлэн Банкны болон бусад этгээдийн үнэт цаасаар төлж болно.
- 13.4. Ногдол ашиг хуваарилахтай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг Банкны ТУЗ-өөс баталсан “Ногдол ашгийн бодлого”-оор зохицуулна.

АРВАН ДӨРӨВ. БАНКНЫ САНХҮҮ БҮРТГЭЛ, ТАЙЛАН

- 14.1. Банкны санхүүгийн жил нь жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж, тухайн жилийн 12 дугаар сарын 31-ний өдөр дуусна.
- 14.2. Банк нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль, болон бусад хууль тогтоомжийн дагуу гаргаж баталгаажуулах бөгөөд тайланг хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна.
- 14.3. Банк нь Компанийн засаглалын үндсэн зарчимд нийцүүлэн санхүүгийн болон санхүүгийн бус тайлан гаргах ба тэдгээр нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна.
- 14.4. Санхүүгийн тайлан нь тайлан тэнцэл, орлого, үр дүнгийн тайлан, хуримтлагдсан ашгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нэмэлт тайлбар, тодруулгаас бүрдэнэ.
- 14.5. Санхүүгийн тайлангуудын үнэн зөвийг ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч хариуцна.
- 14.6. Нэгдмэл сонирхолтой этгээд, Банкны эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд, банкны буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилтныг аудиторроор сонгон ажиллуулахыг хориглоно.

АРВАН ТАВ. БУСАД ЗҮЙЛ

- 15.1. Банкныг өөрчлөн байгуулах, татан буулгах үйл ажиллагааг Монгол Улсын Банкны тухай хууль, уг хуулийн хүрээнд гаргасан журам, бусад хууль тогтоомж болон энэхүү Дүрэмд заасан үндэслэл, журам, хэлбэрээр явуулна.
- 15.2. Дүрмийг Монгол хэлээр 4 (дөрөв) хувь үйлдэн, Банкны тэмдэг дарж, бүртгэх байгууллага, Монголбанк, СЗХ болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргад тус бүр нэг хувийг хадгалуулна.
- 15.3. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хууль тогтоомж болон Дүрэмд заасны дагуу шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт, өөрчлөлт нь Монгол улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн энэ Дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.
- 15.4. Дүрмийг Монгол Улсын хуулийн дагуу тайлбарлаж, зохицуулна. Маргаантай асуудал гарвал Монгол улсын шүүхээр шийдвэрлэнэ.
- 15.5. Дүрмээр нарийвчлан зохицуулаагүй асуудлыг Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

. о о о .

